



“МАТЕРИАЛИМПЭКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 02 сарын 10

Дугаар 07

Улаанбаатар хот

НОГДОЛ АШИГ ХУВААРИЛЖ, ОЛГОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 46, 47, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, “Компанийн дүрэм”-ийн 10 дугаар зүйл, “Компанийн ногдол ашиг хуваарилах журам”, “Төлөөлөн Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 2.4.5 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Материалимпэкс” ХК-ийн 2025 оны цэвэр ашгаас тус компанийн хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн нэгж хувьцаанд ногдох хэмжээг 150 /Нэг зуун тавин / төгрөгөөр тогтоож, хувь хүний орлогын албан татварыг холбогдох хууль тогтоомжийн дагуу суутгасан дүнгээр 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор олгосугай.

2. Ногдол ашиг олгох хэлбэрийг дараах байдлаар тогтоосугай. Үүнд:

2.1. Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид /Б.Зориг, Д.Тунгалаг, З.Цолмон, З.Тогос/-ийн хүсэлтээр ногдох ногдол ашгийг компани дээрээс олгох;

2.2. Бусад хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг ашгийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-тай гэрээ байгуулан, хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар тараан олгох;

3. Ногдол ашиг авах эрхтэй энгийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг компанийн 2026 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын товын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.

4. Ногдол ашиг хуваарилж, тарааж олгох шийдвэрийн тухай мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, хуваарилсан ногдол ашгийг хугацаанд нь олгох асуудалд хяналт тавьж ажиллахыг гүйцэтгэх захирал /Б.Зориг/-т үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ОЮУН